



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²⁴ он ⁰⁵ дугаар
сарын ²⁴-ны өдөр

Дугаар ХЭР/1386

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ТУВААН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын шинжилгээний хариутай холбоотой болон бусад асуудлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга




Ц.НЯМДОРЖ

000021508027

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 05 дугаар сарын 24 -ны өдрийн
Х08/1386 дугаар албан бичгийн хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.ТУВААНААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Коронавирусийн шинжилгээ авах, хариу гарах үйл явцад ХӨСҮТ-ийн эмч, ажилтнуудын оролцоо ямар байгаа, эрүүл.гэрэгэ.мн /eruul.gerege.mn/ сайтад шинжилгээний хариуг хэрхэн шивдэг талаар;

Халдварт өвчин судлалын үндэсний төв Коронавирусийн шинжилгээ авах дарааллыг “Эрүүл.мн” цэсээр бүртгэдэг ба ПОС машинаар хэвлэгдэн гарсан жижиг цаасыг шинжилгээ авсан хуруу шилний гадуур ороож шинжилгээний дараа баталгаажуулах, багцлах ажлыг шинжилгээ авсан хүн өөрөө юмуу сорьц хүлээн авсан хүн оруулдаг. Шинжилгээний хариу гарахад шинжилгээ хийсэн эмч өөрийн нэрээр ПОС машинд хариуг оруулдаг бөгөөд оруулахдаа сорьц дагалдах хуудсын бар кодыг уншуулж “Эрүүл.гэрэгэ.мн”-д эмчийн нэр, он, сар, өдөртэйгөө тэмдэглэн орно. Хариу гаргасан эмч энэ хэсгээс хэн шинжилгээ хийж, хариуг хэзээ оруулсныг харах боломжтой байна.

Асуулга 2. Тагнуулын Ерөнхий газар, Эрүүгийн Цагдаагийн газар ХӨСҮТ-д хамтарсан шалгалт хэзээ оруулсан, хяналт шалгалтын албан ёсны дүгнэлт гарсан эсэх;

Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн Цагдаагийн газраас Халдварт өвчин судлалын үндэсний төвд хамтарсан шалгалт ороогүй болно.

Асуулга 3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээд байгаа ХӨСҮТ-ийн эмч, ажилтнууд олон мянган иргэний шинжилгээний хариу засварласан байж болзошгүй асуудлыг холбогдох хуулийн байгууллага шалгаж байгаа эсэх

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Нийслэлийн прокурорын газраас хянаж Улсын ерөнхий прокурорын А/33 дугаартай тушаалын дагуу Авлигатай тэмцэх газарт харьяалал тогтоож, тус газраас шалгаж байна.

Асуулга 4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр нь дурдагдаж байгаа эмч, ажилтнууд ажлаа хийж байгаа эсэх, шинжилгээний хариу завсарлагдсан гэх тоо баримтын эх сурвалжийн талаар, энэ тоо баримт бодитой байх боломжтой эсэх талаар үндэслэл бүхий мэдээлэл

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн удирдлага алдаа гаргасан зарим албан хаагчдад хариуцлага тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Асуулга 5. Цар тахалтай тэмцэн хүнд нөхцөлд, илүү цагаар ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн илүү цагийн хөлс, урамшуулал,

нөхөн олговрыг бүрэн олгосон эсэх, нийт хэдэн ажилтанд ямар хугацаанд хэдэн төгрөг олгосон талаар;

Цар тахлын үед ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан, албан хаагчдын илүү цагийн хөлсийг олгоход анхаарч 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/27 тоот тушаалаар 457.0 сая төгрөг, 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн А/172 тоот тушаалаар 1.542.0 сая төгрөг, 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/153 тоот тушаалаар 268.5 сая төгрөг, 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн А/173 тоот тушаалаар 1.579.0 сая төгрөг, 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/248 тоот тушаалаар 2.177.7 сая төгрөг, 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/1699 болон А/1700 тоот албан бичгээр 6.795.5 сая төгрөг нийт 12.819.1 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгох шийдвэр гарган олгожээ.

Засгийн газрын 2021 оны 79 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/298 тоот тушаалаар халдвар авсан болон улаан бүсэд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнуудын урамшуулалд 2.580.0 сая төгрөгийг тус тус олгосон.

Асуулга 6. Цар тахлын голомтод дайчилгаагаар ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу цалин хөлсийг нь 3 дахин нэмэгдүүлж олгох ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгох ажлыг хэрэгжүүлэх боломжтой эсэх, цар тахлын голомтод дайчлагдаж ажиллаж байгаа эрүүл мэндийн нийт хэдэн ажилтан байгаа, тэдгээрт хэдэн төгрөг олгох талаар тоо судалгаа гаргасан эсэх, хэрэв ийм тооцоо судалгаа хийгдсэн бол дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлэх;

Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар гүйцэтгэлээр санхүүжих зарим тусламж үйлчилгээг цар тахлын нөхцөл байдлыг харгалзан гүйцэтгэл шаардахгүйгээр 100 хувь олгохоор шийдвэрлүүлж 2021 оны нэг болон хоёрдугаар сарын үлдэгдэл 9,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож тус санхүүжилтийн 70 хүртэлх хувь буюу 6,5 тэрбум төгрөгийг Коронавируст халдвар /Ковид-19/-ын эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оношлох, эмчлэх үйлчилгээнд дайчлагдан ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнуудын илүү цагийн нэмэгдэл хөлсөнд зарцуулахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт Эрүүл мэндийн яамнаас даалган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлс 2018 оноос хойш 3 удаа 26 хувиар, зарим нарийн мэргэжлийн эмч нарын цалин 50 хүртэл хувиар нэмэгдсэн.

Асуулга 7. Эрүүл мэндийн салбарыг улс төржилтөөс ангид байлгах талаар хийж, хэрэгжүүлж байгаа бодлогын ажлынхаа талаарх мэдээллүүдийг ирүүлнэ үү.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, халдварын голомтыг тодорхойлох, хумих, эмчлэх зэрэг бүхий л ажлуудад нүүр тулан эрүүл мэндийн байгууллагын ажилтан албан хаагчид 24 цагийн туршид тасралтгүйгээр халдварт өвчинтэй тэмцэж хүний амь насыг аврахын төлөө улс төржих ямар нэгэн шалтгаан, цаггүйгээр ажиллаж байна.

-----o-----